

**ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТАГ
БА МОНГОЛ УЛС**

Академич Б.БАЛДОО
Дэд доктор Л.ХАЙСАНДАЙ

Хорьдугаар зууны сүүлийн энэ хэдэн жилд дэлхийн улс орнуудын бие биенээсээ харилцан хамаарах явдал улам гүнзгийрэх боллоо. Ялангуяа хүн төрөлхтнийг, дэлхий ертөнцийг үзэл суртлаар хувааж байсан "хүйтэн дайны" үе эцэс болсноор их ба бага, хөгжингүй ба хөгжиж байгаа улсууд өөр өөрсдийн аж төрөн буй тив болон бүс нутгийн хэмжээнд харилцан хүч бололцоогоо нэгтгэн, хамтран ажиллах үйл явц эрч хүчээр авч эхэллээ. Энэ нь дэлхий нийтийн хөгжлийн нэгэн гол чиг хандлага болон хувирч байна. Энэ хандлага, үйл явц өнөө үед дэлхийн томоохон район Ази, Номхон далайн сав газарт бүүр ч эрчимтэй өрнөж байгааг бид бодитой харж байна.

Олон улсын тавцан дээр хамгийн их жин нөлөөтэй гэгдэж байгаа бүс нутаг бол Зүүн хойт Ази (ЗХА) юм. Энэ бүх нутагт Хятад, Орос, Япон, хоёр Солонгос, Монгол улс шууд хамаарагдаж байна. Бас Номхон далайн хойт хэсэгт оршдог гүрнийхээ хувьд АНУ, Канад эндэхийн үйл хэрэгт зүй ёсоор татагдан ордог. Эндээс харахад ЗХА-ийн бүс нутаг бол гол төлөв манай гаригийн хамгийн хүчирхэг, хамгийн нөлөө бүхий их гүрнүүд хөршлөн оршдог гагц бүс нутаг болж байна.

Эдгээр их гүрэн бүс нутгийн төдийгүй дэлхий дахины эдийн засаг, улс төрийн бодлогод асар чухал үүрэг холбогдол, нөлөөтэй байдаг билээ.

Зүүн хойт Азийн бүс нутгийн ялгарах шинж нь тус бүс нутгийн орнууд бие биенээс багагүй ялгаатай байдал юм. Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн хөгжил, газарзүйн байршил, байгалийн баялаг, соёл, ёс заншил, амьдралын хэв маяг, олон улсын тавцан дахь жин нөлөө, аюулгүй байдлын орчин нөхцөл түүний баталгааны хувьд өөр хоорондоо ялгаатайн дээр бас их гүрнүүдийн ашиг сонирхлын ил, далд зөрөлдөөн байдгийг нэмэн дурдах ёстой. Гэхдээ ЗХА нь газар зүйн хувьд хөршилсөн, харилцан хамаарал ихтэй, стратегийн чухал ач холбогдолтой бүс нутгийн нэг юм. Тиймээс тус бүс нутаг нь нийгмийн амьдралын тэргүүлэх салбаруудад хамтын ажиллагааг тогтоон өргөжүүлэх, ялангуяа эдийн засгийг хөгжүүлэх нэн их нөөц баялаг нөхцөл боломж ихтэй юм. Өөрөөр хэлбэл бүс нутгийн улс орон бүр харилцан нэг нэгийгээ сэлбэн нөхөх өөрийн гэсэн давуулаг онцлогуудтай. Энэхүү

харилцан шүтэлцээ, давуулаг онцлогуудыг хамтын ажиллагаагаар зохицуулан хөгжүүлэх өргөн боломжтой. Дурдсан санаан дээр нэмж дурдах зүйл бол сүүлийн жилүүдэд дэлхийн хөгжилд гарсан нааштай шинэчилэлтийн ачаар бүс нутгийн улс орнуудын харилцаанд "хүйтэн дайны" жилүүдэд ашиглагдаагүй байсан нөөцүүдийг хөдөлгөөнд оруулж тэдгээрийг бүрэлдэн эхэлсэн харилцаа холбооны үйл хэрэг, хамтын хөгжил дэвшлийн үйл хэрэгт зориулах бололцоо бий болсон байна. Тухайлбал ОХУ-АНУ, ОХУ-БНХАУ-ын харилцааны нөөцийг үйлдэл хөдөлгөөнд оруулсан юм. Тэгээд их гүрнүүдийн харилцаа сэргөлдөх байдлаас хамтран ажиллах чиглэл рүү шилжих болсон. ОХУ, БНХАУ, АНУ гурван улсын харилцааны эерэг өөрчлөлт нь бие биеийг сөрөн зогссон зэвсэгт хүчин, зэвсэглэлээ алхам алхмаар, үе шаттайгаар, тодорхой хэмжээгээр хорогдуулах боломж буй болгож энэ нь бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, улс орнуудын хооронд хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ нөхцөл, үүд хаалга нээж өгсөн юм. Бас Япон-Оросын харилцааг зогсонги байдлаас гаргасан, хоёр Солонгос улсын харилцаанд нааштай тохиролцоонд хүргэсэн үйл явдлууд нь бүс нутагт харилцан ойлголцох, хамтын ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн билээ.

Сүүлийн жилүүдэд цэрэг-улс төрийн болон үзэл суртлын хурцадмал байдал намжихын хамт бүсийн голлох орнуудад эдийн засаг нийгмийн өөрчлөлт шинэчилэлт явагдаж, зарим талаар бүтцийн чанартай өөрчлөлт гарав. Энэ бүхэн нь геополитикоос геоэкономикт шилжих үйл явцыг нөхцөлдүүлж, эдийн засгийн хөгжлийн асуудлыг төрийн бодлогын тэргүүн чиглэл болгон тавьж, энэ салбарт улс орнуудын хоорондын худалдаа-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг урагшлуулах чухал нөхцөлийг бүрэлдүүлж эхэлсэн юм. ЗХА бүс нутагт оршдог Япон, БНСУ, БНХАУ зэрэг оронд эдийн засгийн хөгжил эрчимтэй өсөлтийн замаар явагдаж байгаа нь бүс нутагт эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд сайн нөлөө өгч байна. Үүний үр дүнд энэ бүс нутгийн улс хоорондын эдийн засгийн харилцаа, хэлхээ холбоо сүүлийн үед төрөл бүрийн салбарт, тухайлан худалдаа, тээвэр, холбоо, жижиг, дунд үйлдвэрлэл зэрэг чиглэлээр идэвхитэй хөгжиж, бүсийн орнууд газарзүй орон зайн хувьд улам ойртох боллоо. Ганц нэгээхэн тодорхой жишээ дурьдвал:

Өнгөрсөн хугацаанд ЗХА-ийн бүс нутгийн улс орнууд жил тутам 250 гаруй тэрбум ам.долларын худалдаа хоорондоо хийж иржээ.¹ Жишээлбэл Япон-Хятадын худалдаа 1995 онд 50 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2000 он гэхэд 100 тэрбум ам.доллар болох төлөвтэй² ажээ. Орос-Хятадын худалдаа, эдийн засгийн хэлхээ холбоо 1980-аад оны дунд үеэс эхлэн хөгжин өргөжиж байна. 1992 оны байдлаар тус хоёр орны хоорондын худалдааны нийт хэмжээ 5,9 тэрбум ам.доллар байсан бол 1993 онд энэ тоо 7,7 тэрбум болж өсчээ.³ Хамтын ажиллагааны тодорхой төслийг хэрэгжүүлэхээр хоёр тал олон арван хэлэлцээр байгуулан ажиллаж байна. Үүний нэг жишээ бол Зүүн хойт Хятадын Ляонин мужид хоёр сая киловаттын хүчин чадалтай атомын цахилгаан станц хоёрыг хамтран барьж байна.⁴

Бүсийн орнуудын хоорондын аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааны гол хэлбэр нь худалдаа боловч бас эдийн засгийн өөр хэлбэрийн харилцаа, хамтын ажиллагаа тэрлэн хэрэгжих боллоо. Хамгийн гол нь түүхэн уламжлал, эдийн засгийн болон хүн хүчний бололцоо, байгалийн ба оюуны баялаг зэргийн үндсэн дээр харилцан шүтэлцээ хамаарал, уламжлалт ба шинээр тогтоосон харилцааг хэрэгжүүлснээр бүсийн улс орнууд харилцан бие биеийг тэтгэх, дутууг харилцан нөхөх бололцоо бүрдэх юм. Энэхүү олон хүчин зүйлийн нөхцөлдсөн байдал нь амьдралын бодит зүйл юм. Харилцан тэтгэх, сэлбэн нөхөх боломжийн үүднээс асуудалд хандвал: Оросын Алс дорнод нь нефть, шатдаг хий, эрдэс баялаг, ой модоор баян бөгөөд ажиллах хүч, газар нутаг, байгалийн баялагтай Монгол нь газар нутаг, эрдэс баялаг, мал аж ахуйн гаралтай түүхий эдээр нэлээн боломжтой, хүчирхэг эдийн засагтай Япон, шинээр үйлдвэржсэн БНСУ нь капитал, хөрөнгө, орчин үеийн үйлдвэрлэл, технологи сайтайн дээр АНУ-ын капитал, өндөр технологийг нэмэн дурьдаж болох бөгөөд эдгээр нь цаашид эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж хөгжүүлэх, бүс нутгийн интеграцыг бүрэлдүүлж тогтоох өргөн боломжийг олгож байгаа юм. Чингэж хамтран ажиллахыг нэг талаас эндэхийн орон бүрийн эдийн засгийн хөгжлийн эрх ашиг, нөгөө талаас өнөөгийн цаг үе буюу дээр өгүүлсэнчлэн дэлхийн улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарал гүнзгийрч, бүсчлэн хамтдаа хөгжих хандлага, интеграцийн үйл явц шаардаж байгаа билээ.

Бүс нутаг дахь эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцийн нэг чухал чиглэл бол бүс нутгийн хэд хэдэн орон, зарим орны тодорхой районыг энэ үйл ажиллагаанд татан оролцуулж өөд татан хөгжүүлэх хүмүүнлэг зорилтыг агуулж байгаа билээ. Тодорхой хэлбэл, Монгол, БНАСАУ, Оросын Алс дорнод, БНХАУ-ын Зүүн хойт хэсгийн эдийн засгийн байдлын тухай өгүүлж байгаа хэрэг юм. Энэ эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох үүднээс ОХУ-ын Алс Дорнодод их Владивостокийн төсөл, БНХАУ-ын Зүүн хойт мужууд ба ӨМӨЗО-ныг хөгжүүлэх төслүүд боловсрогдож, ЗХА-ийн бүс нутгийн интеграцийн явцад хэрэгжигдэхээр яригдаж буй. Энэ хамтын ажиллагааны олон улсын шинжтэй том төсөл бол ОХУ, БНХАУ, БНАСАУ, Монгол улс, БНСУ оролцсон Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төсөл НҮБ-ийн ивгээл дор хэрэгжиж эхлээд буй явдал юм.

Өнөөдөр их, бага улс орнууд цэрэг, зэр зэвсгийн тоогоор бус гагцхүү эдийн засгийн хүчин чадлаараа уралддаг цаг үе ирж байгаа тул эдийн засгаа хөгжүүлэхгүйгээр үндэсний аюулгүй байдлаа ханган хамгаалж үл чадмой. Ийм учраас бүс нутгийн аюулгүй байдал эдийн засгийн хамтын ажиллагаанд шууд нөлөөтэй тул энэ асуудал улс орнуудын анхаарлыг ихэд татдаг.

Хэдийгээр хүйтэн дайны үе шувтарсан ч бүс нутгийн улс төр, эдийн засгийн байдал тогтвортой хэвийн болсон гэж итгэлтэй хэлэхэд

арай эртдэх байх. Өөрөөр хэлбэл ЗХА-ийн аюулгүй байдлын баталгаа бас л тодорхой бус байна гэсэн үг. Энэнд нөлөөлж буй учир шалтгаан бий.

Юуны өмнө дурдахад энд ЗХА-ийн бүс нутгийн улс орнуудын ялгаатай нийгмийн байгуулал ба хөгжлийн түвшиний зөрүү зэрэг урьдаас уламжилсан өв уламжлалын хүчин зүйлс их нөлөөлж байна. Дэлхийд ба бүс нутагт улс төр, эдийн засгийн шинэ дэг журмын талаар их яригдаж буй авч одоохондоо мэдрэгдэж үр дүн өгөөгүй байгаа.

Энэ бүс нутгийн улсууд аюулгүй байдлаа бэхжүүлэх утгаар батлан хамгаалах салбарт оруулах хөрөнгө мөнгөө нэмэгдүүлэх, арми, зэвсэг техникээ шинэчлэх, зэвсэгийн наймаагаар хөөцөлдөх хандлага сүүлийн үед нэмэгдэх болсон. Бүс нутгийн орнуудаас цэргийн салбартаа зарцуулж байгаа зарцуулж байгаа зардлын хэмжээ 1994 онд (Стокгольмийн энх тайвны асуудал судлах олон улсын институтгийн мэдээгээр) олон тэрбум ам.долларт хүрч байв.⁵

Орос, Хятадын харилцаа бүрэн хэвийн болж, хоёр их гүрний түншлэл шинэ шатанд гараад нэлээд жил болж байгаа Оросын зэвсгийг Хятадад худалдан нийлүүлэх явдал сүүлийн үест улам ихсэж энэ нь бүс нутгийн улсуудын (тэдгээрийн дотор Монгол улсын) хувьд хурц асуудал болон тавигдаж байгаа.

Солонгосын хойгийн хоёр орны хоорондын яриа хэлэлцээ үе үе явагддаг боловч хоёр Солонгос нэгдэх арга зам харагдахгүй хэвээр байгаагийн дээр тэдгээрийн хоорондын сүүлийн үеийн харилцаа бүс нутгийн аюулгүй байдалд таагүй нөлөөлөх талтай байгаа.

Оросын улс төрийн байдал төдийлөн тогтвортой биш, тэнд үндэстэн, шашны хамаарал дээр үндэслэсэн сөргөлдөөн үе үе гарсаар байгаа.

Газар нутгийн маргаан, далай тэнгис дэх газрын тос болон бусад баялагтай жижиг арал, хад хясааны төлөө том, жижиг орнуудын хооронд бүүр зэвсэгт сөргөлдөөн ч гарч болзошгүй байгаа зэрэг учир шалтгаантай холбоотой болов уу.

Хэдийгээр ийм байдал, хандлага бодитой байгаа ч энэ бүс нутагт мөргөлдөөн сөргөлдөөнийг өдөөн хатгасан буюу дайн тулаанаар заналхийлсэн тийм улс орон байхгүй гэж нотлох үндэстэй. Энэ нь манай бүс нутгийн орнуудын хөгжил дэвшил, хамтын ажиллагааг өрнүүлэхэд сайн нөлөөтэй гэж үзэлтэй.

Бүс нутгийн улс төрийн аюулгүй байдлын тухай асуудлыг хөндөхөд АНУ-ын ролийг дурдалгүй өнгөрч үл болно. Зүүн хойт Азийн улс төрийн уур амьсгалыг бүс нутгийн их гүрнүүд эн тэргүүнд дэлхийн хамгийн

хүчирхэг гүрэн АНУ-ын бодлого, үйл ажиллагаагаар тодорхойлогдоно Америкийн 100 мянга гаруй хүнтэй цэргийн хүч Япон, Өмнөд Солонгост байрлаж байгаа.¹¹ Энэ нь АНУ-ын удирдах хүмүүсийн хэлдэгээр бүс нутгийн аюулгүй байдлын тогтворжилт, тэнцүү байдлыг хангаж хадгалахад чиглэж байна. АНУ-ын Генерал У.Перригийн мэдэгдсэнээр "АНУ-ын 1945 оноос хойш Азид явуулж байгаа бодлогын зорилго нь энх тайвныг сахиулах, тогтвортой байдлыг хангах, цэцэглэл хөгжлийг дэмжихэд оршиж"¹² байна. Япон улс энэ зууны хоёрдугаар хагаст дэлхийн эдийн засгийн тэргүүн хөгжилтэй орны нэг болсон бөгөөд энэ түвшинд зохицсон цэрэг-улс төрийн байдлыг олох эрмэлзлэлтэй байгаа тухай яриа мэдэгдэл уг улсын удирдах зүтгэлтэн нар хийх болсон нь бүс нутаг дахь анхаарвал зохих нэг чухал хандлага мөн. БНХАУ сүүлийн хоёр арав шахам жилд эдийн засгаа өндөр хурдацтай хөгжүүлж, цэрэг армия модернизацчилах, хүчирхэг их гүрэн болох идэвхтэй бодлого, үйл ажиллагаа явуулах болсон нь дэлхий ба бүс нутгийн геополитикийн орчимд урьдчилан хэлэх аргагүй томоохон өөрчлөлт авчирах төлөвтэй. ОХУ өнөөгийн улс төр, эдийн засгийн тогтворгүй байдлын улмаас урьдын хүчирхэг ролио алдсан боловч дотооддоо үлэмж их потенциалтай, цөмийн зэвсэг бүхий, евроазийг дамнасан том гүрэн хэвээр үлдэж хямралт байдлаас гарах, гадаад бодлогоо идэвхжүүлэхээр эрмэлзэж байгаа нь дэлхий болон бүс нутгийн хөгжилд цаашид нөлөөлөх нь зайлшгүй.

Энд дурдсан эрмэлзлэл хандлагын фон дээр ЗХА-ийн улс төр-аюулгүй байдлыг авч үзвэл эндэх улс орнуудын ашиг сонирхол зөрчилдөх байдал төлөв, тухайлбал бүс нутгийн орнууд (Япон, Хятад, Орос, хоёр Солонгос)-ын хооронд болон тэдгээр орон ба АНУ-ын хоорондын харилцаанд аль нэг хэмжээгээр ажиглагдаж байгаа гэж хэлмээр байна.

Өнөөдрийн энэ ажиглагдаж буй зөрчил үндсэндээ эдийн засгийн нөлөөгөө ихэсгэх, шинэ зах зээлийн төлөө тэмцлийн хэлбэрээр явагдах төлөвтэй ч энэ нь бүс нутгийн аюулгүй байдлыг эмзэг болгох нь ойлгомжтой. Энд зарим нэг ажиглалтыг дурдвал:

Япон, АНУ-ын харилцааны хувьд гэвэл худалдаа-эдийн засаг, иен-долларын ханшны зөрөөтэй асуудал хоёр улсын хооронд байгаа боловч энэ нь хожмоо улс төрийн харилцаанд ч түвэгтэй байдал бий болгож болзошгүй төлөв илэрч байна. Америкийн цэргийг Японоос гаргах, Японд байгаа Америкийн цэргийн зарим зардлыг Японы тал даахгүй байх, хэмнэсэн хөрөнгөөр Японы батлан хамгаалах хүч чадлыг зузаатгах гэсэн аястай япончуудын шаардлага, ялангуяа америкийн цэргийн Японд үйлдсэн хүчингийн хэргийн дараагаар нэлээд гарах боллоо.

БНХАУ, АНУ-ын харилцаанд бол энэ нь Тайваны асуудал, Хятад-Америкийн худалдаа, Хятад дахь хүний эрхийн асуудал гэх мэтийг тойрон хоёр орны харилцаа үе үе маргаантай болдог байна.

Орос, Японы харилцаанд газар нутгийн маргаан нэлээдгүй нөлөөлж байна.

Хоёр Солонгосын хоорондын харилцааны асуудлаар их гүрнүүдийн ашиг сонирхол зөрчилтэй хэвээр байна.

Хятад, Оросын түншлэлийн зарим дээр тулгуурласан харилцаан дахь жанжлал, зэвсгийн худалдаа, хөршүүдтэй харилцах асуудал зэрэг нь анхаарвал зохих судалгааны зүйл мөн.

Энэ бүхнээс дүгнэлт хийж үзэхэд ЗХА-ийн бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн хөгжлийн төлөвт нөлөөлөх гол хүчин зүйл бол тус бүс нутгийн том гүрнүүд-Хятад, АНУ, Орос, Японы хоорондын харилцаа, тэдний байр суурь, бодлого юм. Тэр дундаас Хятад-Америкийн харилцаа онцгой чухал бөгөөд энэ хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанаас бүс нутгийн бүхий л төлөв байдал ихээхэн шалтгаалах болно.

Хөгжил дэвшлийн асуудлыг зөвхөн нэг орны хүрээнд биш дэлхийн ба бүс нутгийн хүрээнд хамтын ажиллагаагаар шийдэх болж буй өнөөгийн нөхцөлд Монгол улсын хөгжил, үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах таатай нөхцөл бүрэлдүүлэх явдал тус улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн.

Монгол орны гадаад дотоод орчны өнөөгийн өөрчлөлттэй хамт тус улсын гадаад бодлого шинэчлэгдэж эхэлсэн билээ. Чухамдаа ийм өөрчлөлтийн үр дүнд Монгол улс харьцангуй бие даасан, үндэсний эрх ашгаа дээдэлсэн, нээлттэй гадаад бодлого явуулах боломжтой болсон юм.

Ийм гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн асуудлыг хөндөхийн өмнө өнөөдрийн Монгол улс олон улсын харилцааны субъектын хувьд чухамдаа ямар ямар өгөгдөхүүнтэй улс вэ гэдэг талаар товч зүйл өгүүлье.

Монгол улсын нутаг дэвсгэр нь 1,5 сая гаруй ам.дөрвөлжин км, хүн нь 1996 оны байдлаар 2,3 сая гаруй байв. Энэ нь дэлхийн 200-аад улс орны дотор хүн амаараа 133 дугаар байранд, газар нутгийн хэмжээгээр 18 дугаар байранд орж байна гэсэн үг.

Монгол оронд Номхон далай, Хойт мөсөн далайд цутгадаг Төв Азийн цэнгэг усны хагалбар багтаж байдаг бөгөөд 67 мянга гаруй км урт гол мөрөн, 4 мянгаад нуур бийн дотор Төв Азид хамгийн гүнд (262 м) тооцогддог цэнгэг уст Хөвсгөл нуур, тогтмол нууруудаас хамгийн том нь Увс нуур (усны талбай нь 3350 ам.км) байна. Монголд 2 мянга гаруй зүйл ургамал, 10 мянга гаруй амьтан бий.

Мал аж ахуй бол Монголын эдийн засгийн нэг гол чухал салбар бөгөөд 1996 оны байдлаар нийт мал (хонь, үхэр, адуу, ямаа, тэмээ)-ын

гоо толгой 29 сая гаруй байв. Монгол оронд алт, мөнгө, зэс, молибден, жонш, уран, волфром, фосфор, хөнгөн цагаан, хар тугалга зэрэг байгалийн эрдэс баялгийн 240-аад орд байгаа юм. Тэдгээрийн заримаас жишээ болгон дурдвал:

-Монголд зэс молибдений хэд хэдэн том орд байгаагаас одоо ашиглагдаж байгаа нь Эрдэнэтийн овооны орд газар бөгөөд эл овооны ил уурхай нь жилд 20 сая тонн (1996 онд 21,5 сая тонн) зэсийн хүдэр олборлох хүчин чадалтай бөгөөд одоо ашиглаж буй орд газарт нэг тэрбум 500 сая тонн хүдэр бий. Уг орд газрыг түшиглэж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр байгуулан ажиллуулж байгаа билээ. "Эрдэнэт" үйлдвэрээс жилд 120 мянган тонн зэс агуулсан баяжмалыг гадаадад гаргадаг. 1997 онд тус орд газарт АНУ-тай хамтарч жилд 3,6-3,7 мянган тонн цэвэр зэс үйлдвэрлэх "Эрдэмин" үйлдвэрийг ашиглалтанд оруулав.

-Монголд алтны үйлдвэрлэл хөгжиж байна. 1993-1994 онд 1,3-2,0 мянган тонн алт олборлож байсан бол 1996 онд 6,1 мянган тоннд хүргэв. Алт олборлох 50 гаруй компани ажиллаж байгаагийг олонхи нь хувийнх юм. Монголд алт олборлох гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол сүүлийн үед нэмэгдэж буй.

-1994-1996 онд манай улс АНУ-ын хэд хэдэн компанитай хамтран газрын тосны эрэл хайгуул, өрөмдлөгө хийсэн. Дорнод монголын Тамсагийн сав газраас олборлож болох газрын тосны нөөц нь 500 саяас нэг тэрбум баррельд хүрнэ гэсэн судалгааны мэдээлэл бий. Эндээс гаргаж авсан тосны дээжсийг шинжилж үзэхэд 41 нэгжтэй гарсан нь дээд зэргийн чанартай тос байх нь тодров. Ойрын жилүүдийн өрөмдлөгүүдийн үр дүн монголын газрын тосны тухай асуудалд хөдлөшгүй хариу өгөх болно. Монгол улс олон улсын харилцааны субъектын хувьд иймэрхүү өгөгдэхүүнтэй гэж тоймлон хэлж болохоор байна. Өөрөөр хэлбэл гадаад түншийн нүдээр харахад бидний давуу болон сул тал эндээс эхэлнэ.

1994 онд Улсын их хурлаас баталсан "Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал" гэдэг баримт бичигт тус улсын гадаад бодлогын тэргүүлэх зорилтыг 6 чиглэлд ангилж тодорхойлжээ. Эдгээр нь хоёр хөрштэй, өрнө, дорнын өндөр хөгжилтэй улсуудтай, Азийн бүс нутагтай, хуучин "Социалист" гэгдэж байсан болон одоо шинээр тусгаар тогтносон орнуудтай, хөгжиж байгаа улсуудтай, олон улсын байгууллагуудтай найрсаг харилцаж хамтран ажиллах чиглэл бодлого юм. Эдгээрийн дотроос манай гадаад бодлогын эн тэргүүний зорилт бол хөрш хоёр гүрэнтэй найрсаг харилцаа, тал бүрийн хамтын ажиллагаа хөгжүүлэх явдал юм. Яагаад гэвэл тус улсын аюулгүй байдал, хөгжил дэвшил энэ хоёр их хөрштэй хэрхэн харилцахаас үлэмж хамааралтай байдаг. Чухамдаа тэдгээрийн ашиг сонирхлын уулзвар ба тэнцвэр дээр тэдэнтэй арга эвээр харилцаж туурга тусгаар оршин тогтнож ирсэн, одоо

ч тогтнож байна.Цаашдаа ч тийм л байх болно.Тэгэхдээ хоёр их хөршийн аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, хоёулантай нь тэнцвэртэй харилцах чиг шугамыг барих бөгөөд ялангуяа тэдний зүгээс "Монгол улсын үндэсний язгуур эрх ашгийн талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгалзан тусгаж байх.Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож төвийг сахих бодлого баримтлахыг"¹³ тус улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд чухалчлан заажээ.

Тус улсын гадаад бодлогын хоёр дахь чухал чиглэл бол Өрнө, Дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх зорилт юм.Энэ зорилтын хүрээнд АНУ, Япон, Европын холбоотой харилцаа хөгжүүлэх, идэвхитэй хамтран ажиллахыг онцлон анхаарч байна.Энэ улс гүрнүүдтэй харилцах харилцаанд, ялангуяа эдийн засгийн хэлхээ холбоо хөгжүүлэх, тэдний эдийн засгийн ашиг сонирхлыг Монголд бий болгож хөрөнгө оруулах, түүний хамт тэдний найдвартай түнш нь болох чиглэлд ихээхэн хүч чармайлт тавих хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой юм.

Монгол улсын гадаад бодлогын дээрх хоёр чиглэлээс үүдэн гарч буй гуравдахь гол чухал чиглэл нь Азийн бүс нутагт Азийн орныхоо статусыг жинхэнэ ёсоор сэргээж, байр сууриа бататгах, эндэхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал юм.Энэ зорилтын хүрээнд Төв Азийн чиглэлд түлхүү анхаарал тавих боллоо.Энэ нь зүй ёсны бөгөөд бодит зүйл юм.Ази, Номхон далайн салбар бүс нутаг дотроос Зүүн хойт Ази нь эдүгээ болон цаашдаа Монгол улсын гадаад харилцаанд тэргүүн зэргийн нөлөөтэй, ач холбогдолтой байх болно гэж үзэж байна.Энд манай гаригийн хамгийн их нөлөө бүхий хүчирхэг том гүрнүүдийн ашиг сонирхол төвлөрч байдаг,тэгээд ч Монгол улс тэдний ашиг сонирхлын хүрээнд багтаж байгаа юм.

Монгол улс газарзүйн байрлалынхаа хувьд Төв Азид оршдог.Хэдийгээр Төв Ази гэдэг нэлээн эртний уламжлалт нэр томъёо боловч Ази, Номхон далайн бүс нутаг, Зүүн өмнөд Ази зэрэгтэй харьцуулахад бүс нутгийн улс орнуудын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралыг зохицуулах механизим бүрэлдэж тогтоогүй, зөвхөн газарзүйн ойлголт хэвээр байна.Төв Азийг бүс нутаг болгож буй хүчин зүйл нь газар нутаг, түүхийн үндэслэлээс гадна угсаатны, нүүдлийн соёл иргэшлийн хэлхээ холбоо юм.Сүүлийн үед өрнөж байгаа өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд энэ бүсэд шинээр тусгаар тогтносон улсуудтай худалдаа, эдийн засаг, улс төр, иргэдийн харилцаанд мэдэгдэхүйц ахиц гарч, идэвхижих байдал ажиглагдаж байна.Мөн Монгол улс ОХУ-ын хил залгаа Буриад, Тува, Уулын Алтай болон Чит мужтай олон салбарт холбоо хэлхээг өргөтгөн гэрээ хэлэлцээр байгуулав.Энэ бүхний дүнд худалдаа, эдийн засаг, соёл,аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааны шинэ маягийн харилцааны эхлэл тавигдаж байна.БНХАУ-ын Өвөр Монгол, Шинжаантай зарим салбарын хамтын ажиллагаа, хилийн худалдаа өргөжиж, хэд хэдэн хилийн боомт шинээр нээн ажиллуулж байна.Зам харилцааны салбарт ч нааштай алхмууд хийгдэж эхэлж

байна. Гэвч тодорхой шалтгаануудын улмаас Төв Азийн бүс нутаг гэсэн идэвхитэй, үйл ажиллагааны томоохон багтаамж бүхий бүхэл бүтэн тогтолцоо ойрын үед бүрэлдэн тогтох үндэслэл тун бага байна.

Ийм учраас Монгол улсын хувьд нийгэм-эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааны нэгдсэн механизм бүрэлдэн тогтох үйл явц өрнөж байгаа, энэ талаар ихээхэн найдвар төрүүлж буй “Зүүн хойт Азийн бүс нутаг”-ийн хүрээнд хамааран орж энэ бүс нутгийн улс орнуудтай идэвхитэй харилцаа, хамтын ажиллагаа өрнүүлэх нь илүү боломжтой, үр дүнтэй юм.

Монгол улс олон давуу тал, хүчин зүйлээрээ энэ салбар бүс нутагт багтах ёстойг дэлхийн Ази судлаачид (Р.Скалапино болон бусад), түүнчлэн Азийн улс орнуудын удирдлага дотор ч хүлээн зөвшөөрч байна¹⁶. Энэ бүсэд Монгол улсын хамаарахын гол үндэслэл юу вэ гэвэл:

Юуны өмнө байгаль газар зүйн талаас Монгол орны зүүн хэсэг бүхэлдээ АНД-н энэхүү салбар бүсэд шууд хамаарагдана. Манай орны нийт газар зүйн тогтоц нь Номхон далайн зүйгт хэвийсэн байрлалтай учир олон арван гол мөрөн түүнд цутгадаг. Монголын байгалийн эрдэс баялаг, ан амьтан, цаг уур зэрэг нь олон талаар тухайн бүс нутагтай нягт холбогдсон, харилцан шүтэлцээ, хамааралтай байдаг билээ. Тийнхүү Монгол орны байгаль орчны экологийн асуудал, түүний тэнцэл, цэвэр ариун байдал Зүүн хойт Азийн экологийн асуудалтай, түүгээр дамжин нийт Ази, Номхон далайн бүс нутагтаа салшгүй холбоотой юм. Энэ бүхэн бол зөвхөн газарзүй, байгаль орчны тал нь.

Нөгөө нэг тал нь гэвэл Монгол орон бол Хятад, Орос хоёрыг, улмаар Зүүн Азийг Европтой хамгийн дөт замаар холбож байдаг уулзвар газар. Үүгээрээ агаар, төмөр замын болон автозамын тээвэр, харилцаа холбооны чухал зангилаа болсон онцлог байрлалтай орон бөлгөө. Энэ утгаараа дорно, өрнийн хоёр соёл иргэншлийг холбогч холбоо гүүр гэлтэй.

Зүүн хойт Ази нь Монголын хувьд бас түүх соёлын уламжлалт хэлхээ холбоо, зан заншил, сүсэг бишрэл, аж төрөх байдлаараа ойр дөт, олон талаар адил төстэй юм. Манай орон далайд гарах гарцыг энэ нутгаар дамжин олох юм. Монгол улсын цаашдын хөгжилд нэн шаардлагатай хөрөнгө капитал, техник, технологийн эх үүсвэр ч энэ бүсийн орнуудад бий. Монгол улс өөрөө байгалийнхаа эрдэс баялаг, агаар ус, газар шороо болон мал аж ахуйн голдуу гаралтай төрөл бүрийн түүхий эд зэрэг олон давуу тал, хүчин зүйлээрээ энэ бүсийн улс орнуудад ашиг тустай нь бас тодорхой. Иймд Монгол улс ихээхэн ирээдүй бүхий энэ бүс нутагт байр сууриа олж бататган, хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг бүхий л аргаар өрнүүлэн хөгжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, мөн интеграцийн үйлсэд дөхөм үзүүлэхийг зорьж байгаа билээ. “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд” ...Азийн

бүс нутагт байр сууриа бататгаж, эндэхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох,"...Зүүн хойт Азийн ... чиглэлд түлхүүр" анхаарах явдал гадаад бодолтын нэг чухал чиглэл гэж онцлон заасан юм.

Энэ зорилт нь эцсийн бүлэгт өөрийн улсын гадаад харилцааг өрөөсгөл хандлагаас ангижруулж, Монголын талаархи их гүрнүүдийн болон нөлөө бүхий бусад улсын ашиг сонирхлыг аажмаар тэнцвэржүүлэхэд тус дөхөм болно. Ингэснээр улс орны аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах нэн чухал гадаад орчин Монгол Зүүн хойт Азийн бүс нутагт хамаарагдсанаар бүрдэнэ гэж төсөөлж байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг нь дотоод их потенциалтай голдуу том гүрнүүдээс бүрдсэн бус боловч хамтын ажиллагаагаа зохиохын хувьд АНД-ын бусад районуудаас хоцорч, энд хамтын ажиллагааны бүтэц бүрэлдээгүй, удирдлага болгон баримтлах баримт бичгүүд боловсрогдоогүй байна. Үүний шалтгаан нь дээр дурдсан улс төрийн шалтгаан нөхцөлөөс гадна бас дэд бүтэц хөгжөөгүй явдал гэж бүс нутгийн мэргэжилтэн нар үзэж байна. Гэвч бүс нутаг гэдэг ойлголт хэдийнээ газар зүйн байхаа больж, улс төр-эдийн засгийн өнгө аясыг олжээ. Бүс нутагт явагдаж буй хамтын ажиллагаа үндсэндээ худалдаа, эдийн засгийг хамран голдуу хоёр талын үндсэн дээр, гэхдээ эдгээрийг нийлүүлж үзвэл олон талын үндсэн дээр явагдаж байна гэж үзэж болохоор.

Тэгэвч бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоо, арга замыг судлах, өөрөөр хэлбэл хамтын оюун санааны бэлтгэл ажил өргөмж явагдаж ирсэн байна. Энэ үйл хэрэгт бүс нутгийн орнуудад байгуулагдсан Зүүн хойт Азийн судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд, онцолбол АНУ-ын Гонолулу хотын "Өрнө, Дорно төв" хэмээх судалгааны байгууллага ихээхэн үүрэг гүйцэтгэснийг тэмдэглүүштэй. Энэ байгууллагын санаачилга, бусад эрдэм шинжилгээний байгууллагын дэмжлэгтэйгээр 80-аад оны эцсээс Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны цуврал бага хурлуудыг ("Чанчуны" ч гэдэг) бүс нутгийн эрдэмтэд, улс төрчид, бизнесменүүдийн оролцолгоотойгоор зохион явуулж, ном зохиол, эмхэтгэлүүдийг нийтэлж байгаа юм. Энэ судалгааны үйл ажил хамтын ажиллагаа, интеграцийн үйл явцад их нөлөө үзүүлжээ. Манай улс үүний нөлөөгөөр өөрийн судалгааны ажлыг эхлэн дэлгэрүүлэн, ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийг байгуулсан. Монголын төлөөлөгчид бага хурал, уулзалт, симпозиумд байнга оролцон, манай эдийн засагчид судалгааны бүтээлүүдэд нь нийтлэлээ хэвлүүлж ирэв.

"Өрнө, Дорно төвийн" бага хуралд оролцогчид 1990-ээд оны эхээр бүс нутгийн хамтын төсөл болох "Түмэн голын сав газрыг хөгжүүлэх хөтөлбөр" гэдгийг санаачилсан юм. Энэ хөтөлбөр НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжих болсон юм. Энэ төсөл БНХАУ-ын Зүүн хойт мужууд, ОХУ-ын Алс Дорнод, БНАСАУ-ын дундын төсөл хэлбэрээр

үүсэн гарч, түүнд БНСУ, Монгол улс, Япон улс хамтран оролцох болжээ. Төсөлд оролцож байгаа улсуудын нийгмийн тогтолцоонд ялгаа байлаа ч ЗХА-ийн ирээдүйн хөгжилд асар их рольтой энэ олон улсын арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хүчин чармайлт, өөрт буй давуулаг талаа хорших ажлыг урагшлуулахаар ажиллаж эхэлсэн юм. Энэ баримт бичиг улс тус бүрийн бие биенээ нөхөх боломжийг дайчилах, системийн ялгаатай улс орон хамтран ажиллаж болохыг нотлох сонин жишээ болох юм гэж судлаачид үздэг. Энэ төслийг хэрэгжүүлэх ажил хоёр шаттай (1992-1994, 1995-аас хойш) явагдаж хоёр дахь шатанд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зохих таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээг сайжруулах гэсэн дөрвөн чиглэлд хэрэгжүүлэх, Түмэн голын хөгжлийн хамтын ажиллагааны хэлэлцээр, Түмэн голын хөгжлийн захиргаа байгуулах мэт нэлээд асуудлыг шийдвэрлэх чигт өрнөсөн юм.

Монгол улс Зүүн хойт Азийн бүс нутаг, түүний Түмэн голын хөтөлбөрт хамаарахдаа энэ талаархи өөрийн стратегийн зорилтыг тодорхойлсон юм. Үүний гол зорилго бол тогтвортой хөгжил ба улс үндэстний нийгмийн амьдралын хөгжлийг хурдан өөд татах нөхцөлийг буй болгоход чиглэсэн юм. Манай улс ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа, Түмэн голын төсөлд оролцсоноор энд өөрийн тохирох байр суурийг олж авах, бүс нутгийн гишүүн гэсэн өөрийн статусыг цаашид нотлох болно.

Төсөлд оролцохдоо бид ямар стратегийн гол зорилт тавив гэвэл:

-Бүс нутгийн мэдээлэл, холбоо харилцааны сүлжээ, зам тээврийн системд багтан дэлхийн эдийн засагт орох зохистой арга замыг олох.

-Дотоод нөөцийг сайтар ашиглан зам харгуй, тээврийн хэрэгслийг хөгжүүлэх.

-Дорнод Монголын газар нутагт эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, энэ бүсийг Түмэн голын хөгжлийн төслийн умартын нэгэн туйл (полюс) болгон хөгжүүлэх.

-Дорнод мужийг ЗХА-ийн төмөр замтай холбох, ирээдүйд авто замын сүлжээнд холбох, Ази Европа хоёрыг холбосон "хуурай замын гүүр"-ийг байгуулах нөхцөлийг бүрдүүлэх.

-Сибирийн байгалийн шатдаг хийн хоолойг Монголоор дайруулан тавьж, Зүүн Азийн орнуудад хүргэх ажилд хувь нэмэр оруулах.

-Түмэн голын төслийн талаархи болон бусад яриа хэлэлцээнд идэвхитэй оролцож хувь нэмэр оруулах зэрэг томоохон зорилтууд дэвшүүлсэн бөгөөд энэ нь манай улсын төр, аж ахуй, судалгааны байгууллагуудын идэвхитэй бүтээлч ажиллагааг шаардаж буй. Дээр дурьдсан зорилтуудыг ажил хэрэг болгоход газрын баялаг, газрын тосны орд газарт хайгуул болон үйлдвэрлэлийн ажил өрнүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих талаар Монгол улсын Засгийн газраас авч байгаа арга хэмжээ чухал ач холбогдолтой болно.

Монгол улсаас Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудтай тогтоосон хэлхээ холбоог тууштай, шатлалтай, аажим, ухаалаг бөгөөд улам

тодорхой болгон өрнүүлэх нь Монголын ард түмний ирээдүйн хөгжлийн хувь заяанд үлэмж ач тус хүргэнэ. Энэ нь Монгол улс дэлхийн хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд тэдгээртэй гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн харилцаагаа өргөтгөн гүнзгийрүүлэх нэгэн чухал чиглэл болж байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гол нутаг болж байна. Энэ бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд тэдгээртэй гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн харилцаагаа өргөтгөн гүнзгийрүүлэх нэгэн чухал чиглэл болж байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гол нутаг болж байна. Энэ бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд тэдгээртэй гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн харилцаагаа өргөтгөн гүнзгийрүүлэх нэгэн чухал чиглэл болж байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гол нутаг болж байна. Энэ бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд тэдгээртэй гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн харилцаагаа өргөтгөн гүнзгийрүүлэх нэгэн чухал чиглэл болж байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гол нутаг болж байна. Энэ бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд тэдгээртэй гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн харилцаагаа өргөтгөн гүнзгийрүүлэх нэгэн чухал чиглэл болж байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гол нутаг болж байна. Энэ бүс нутаг нь дэлхийн хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд тэдгээртэй гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн харилцаагаа өргөтгөн гүнзгийрүүлэх нэгэн чухал чиглэл болж байна.